



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 475

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам"-ын 6.2.5, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй цаашид засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тогтоогдсон нийт 1,532,300.00 (нэг сая таван зуун гучин хоёр мянга гурван зуун) төгрөгийн балансын үнэ, 1,392,745.18 (нэг сая гурван зуун ерэн хоёр мянга долоон зуун дөчин таван төгрөг арван найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргалд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
 2018 оны 10 дугаар сарын 30 ны өдрийн
 43 дугаар тогтоолын хаворалт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН БАЛАНСАД БҮРТГЭЛТЭЙ
 АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл үнэ
1	Хивс 2*3	08.09.30	195,300.00	1	195,300.00	192,045.00	3,255.00
2	Хивс 2*3	12.01.23	258,000.00	1	258,000.00	167,700.00	90,300.00
3	Цаас устгалч	13.12.05	310,000.00	1	310,000.00	279,000.18	30,999.82
4	Цаас устгалч	13.03.13	319,000.00	1	319,000.00	319,000.00	-
5	Цаас устгалч	13.08.21	450,000.00	1	450,000.00	435,000.00	15,000.00
НИЙТ						1,392,745.18	139,554.82
					(нэг сая таван зуун тучин хоёр мянга гурван зуун мянган)	(нэг сая гурван зуун ерэн хоёр мянга долоон зуун дөчин таван төгрөг арван найман мөнгө)	(нэг зуун тучин есөн мянга таван зуун тавин дөрвөн төгрөг наян хоёр мөнгө)